

МАЛ АЖ АХУЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ
Онцгой нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг

**2020-2021 ОНЫ ЗУДЫН ГАМШГИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ:
БОНХМБ-ЫН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

2020 оны 12 дугаар сар (2021 оны 5 дугаар сард шинэчилэв)

ГАРЧИГ

1. Ерөнхий мэдээлэл	3
2. Байгаль орчин, нийгмийн эрсдлийн ерөнхий үнэлгээ	9
3. Болзошгүй нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ.....	13
4. Байгаль орчин ба нийгмийн менежментийн үйл ажиллагаа	17
5. Байгууллагын зохион байгуулалт ба чадавхийг бэхжүүлэх.....	17
6. Гомдол шийдвэрлэх механизм	22

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 ОНБҮХХАХБХ-ийн урьдчилан төлөвлөсөн үйл ажиллагаа	5
Хүснэгт 2 ОНБҮХХАХБХ-ийн үйл ажиллагааны БОН-ийн ерөнхий үнэлгээ.....	9
Хүснэгт 3 Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	13
Хүснэгт 4 ОНБҮХХАХБХ-ийн зөвлөлдөх хэлэлцүүлэг.....	19
Хүснэгт 5 Зөвлөлдөх үүлзалтын хураангуй.....	19

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Зудын эрсдлийн үнэлгээний зураглал	3
Зураг 2 Зуд, ковид-19, шороон шуурганы хавсарсан нөхцөл байдал, 2021 оны 4 сарын 10-ны байдлаар	4


ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БОНҮ	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНХМБ	Байгаль орчин, нийгмийн хамгааллын менежментийн бодлого
БОН	Байгаль орчин, нийгэм
ГШМ	Гомдол шийдвэрлэх механизм
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МААЭЗЭНТ	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОНБҮХХАХБХ	Онцгой нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХЭМАБ	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал
ЭМАБХО	Эрүүл мэнд, аюулгүй байдал ба хүрээлэн буй орчин

МАЛ АЖ АХУЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГОД ОРУУЛАХ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН (ОНБУХХАХБХ) ТАЛААРХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

1. Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Онцгой Комиссын гүйцэтгэсэн Зудын эрсдлийн хамгийн сүүлийн үнэлгээгээр Баянхонгор, Өвөрхангай, Дундговь аймгийг бүхэлдээ, мөн түүнчлэн Говь-Алтай, Өмнөговь аймгийн зарим сумдуудад зудын эрсдлийн түвшин “өндөр”, “маш өндөр” гэж гарсан. (Зураг 1).




Зураг 1 Зудын эрсдлийн үнэлгээний зураглал

Иймээс Монгол улсын Засгийн газраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамаар дамжуулан (ХХААХҮЯ) Онцгой нөхцөл байдал үүссэн хэмээн үзэж мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл (МААЭЗЭНТ)-ийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсгийг идэвхижүүлэхээр шийдвэрлэсэн. МААЭЗЭНТ-ийн санхүүжилтээс ойролцоогоор 5 сая ам.долларыг энэ бүрэлдэхүүн хэсэгт хуваарилна. ОНБУХХАХБХ-ийн үйл ажиллагааны үр ашгийг эдгээр 5 аймгийн болон Сүхбаатар, Дорноговь аймгийн отрын бүс нутагт өвөлжиж байгаа 45 750 орчим малчин өрх хүртэнэ. Түүнчлэн малчдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох нэмэлт судалгааг хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2021 оны 5 дугаар сарын байдлаар шинэчлэв: 2020 - 2021 онуудын хаваржилт болон өвөлжилтийн үүссэн нөхцөл байдалтай зэрэгцсэн зуд болон бусад байгалийн онц үзэгдлүүд нь малчдын амьжиргааг эрс доройтуулж байна. Эдгээр хүчин зүйлүүдийг дурдвал (i) КОВИД-19 цар тахал улс даяар хурдацтай тархсан ба 19 аймагт (нийт 21 аймгийн) халдвар бүртгэгдсэн, (ii) 3 дугаар сарын 13-14 өдрүүдэд Монгол Улсын ихэнх нутгаар хүчтэй шороон болон цасан шуурга дэгдсэн. Үргэлжилж буй зуд болон КОВИД-19 цар тахалтай давхацсан хүчтэй шороон болон цасан шуурга нь нийт малчдын эмзэг байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Хөл хорионы улмаас үнийн хөөрөгдөл үүсэж, хомсдол бий болсон ба малчид бэлэн мөнгөний орлого олдог улиралдаа амьжиргааны гол эх үүсвэр болох малаа алдсан нь тэднийг өдөр тутмын хэрэгцээгээ хангах бэлэн мөнгөний дутагдалд оруулсан. Түүнчлэн даван туулах, дасан зохицох чадварыг бэхжүүлэх, бий болгох замаар орон нутгийг зуд тохиолдох үед даван туулахад нь бэлдэх шаардлага байгааг тогтоосон. Бүсийн хэмжээнд стратегийн байршлуудад тэжээл үйлдвэрлэлийн

төвүүд нэн хэрэгцээтэй байгаа ба БОБХАХ-н эх үүсвэрээс уг төвүүдийг санхүүжүүлэх боломжтой байна.



Зураг 2 Зуд, ковид-19, шороон шуурганы хавсарсан нөхцөл байдал, 2021 оны 4 сарын 10-ны байдлаар

Өмнө байсан болон шинээр бий болсон хүчин зүйлүүдийн нэгдсэн нөлөөлөл нь БОБХАХ-н төсвийг дахин хуваарилах үндэслэл болно. Тиймээс одоо хэрэгжиж буй малын тэжээл тараах ажиллагаанд дараах 2 шинэ багцыг нэмж оруулах санал гаргаж байна: (i) малчин өрхүүдэд нийгмийн тусламжийн багцыг бэлэн мөнгө хэлбэрээр олгох мөн (ii) цаг уурын даван туулах, дасан зохицох багцыг бүс нутагт малын тэжээл үйлдвэрлэх цэг болон иргэдэд суурилсан бэлэн байдлын үзүүлэх сургалт хэлбэрээр зардал хуваан санхүүжүүлэх зарчмаар зохион байгуулах. Эхний багц болон тэжээл олголт нь хариу арга хэмжээний багцад хамаарах бол хоёр дахь багц нь нийгмийн тусламж буюу онцгой байдлын тусламжийн багц бөгөөд гурав дахь багц буюу иргэдэд суурилсан үзүүлэх сургалт болон бүс нутгийн тэжээл үйлдвэрлэлийн нэгжүүдийг дэмжих нь даван туулах, дасан зохицох багц юм. БОБХАХ-н зохистой дахин хуваарилалтын дараа зохих засваруудыг оруулна.

Ашиг хүртэгчид болон газарзүйн байршлын хувьд БОБХАХ тусламжийн багцаас 21 аймаг болон Улаанбаатар хотод оршин суудаг 180,000 гаруй малчин өрх ашиг хүртэнэ. Цөөн тооны малтай малчид, Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын цаатангууд зэрэг Монгол Улсын бүх малчин өрх энэхүү тусламжийн багцаас ашиг хүртэх ба ХХААХҮЯ малчин өрхүүдийн мэдээллийн үнэн бодит байдлыг баталгаажуулж, тусламжийн багцын холбогдох мэдээллийг орон нутгийн зохих хэрэглэгддэг хэл дээр түгээнэ. Харин БОБХАХ-н даван туулах, дасан зохицох чадавхын багцаас Монгол Улсын төв болон баруун бүсийн нутаг дахь бүх малчин өрх болон мал аж ахуйн бизнесүүд шууд бусаар ашиг хүртэнэ. БОБХАХ-н үйл ажиллагаануудыг Хүснэгт 1-т харуулсан ба холбогдох байгаль орчин, нийгмийн эрсдэлүүд болон нөлөөллийг бүүруулах арга хэмжээний хамт тайлангийн дараах хэсэгт оруулсан.

БОБХАХ-н хариу арга хэмжээ багцын үйл ажиллагаанууд 2021 оны 1-5 саруудын хооронд хэрэгжиж дуусах төлөвтэй байгаа бол шинээр санал болгосон тусламжийн багцыг Засгийн газрын (Сангийн яам болон Төрийн сан) бэлэн мөнгө шилжүүлэх системд хийх Дэлхий банкны

шалгалттай уялдуулан 2021 оны 5 дугаар сарын дундуур хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөж байна. Харин даван туулах, дасан зохицох чадавхын багцын хүрээнд төслийн Бүтээмжит түншлэлийн төлөвлөгөөний дагуу өрсөлдөөнт сонгон шалгаруулалт хийгдэх тул хэрэгжилтэд нь хугацаа шаардагдах ба энэ жилийн эцэс хүртэл үргэлжилнэ. Энэхүү багцын бодит гүйцэтгэл нь КОВИД 19-н хөл хорио болон хязгаарлалтуудаас ихээхэн хамаарна.

Хүснэгт 1 ОНБУУХАХБХ-ийн урьдчилан төлөвлөсөн үйл ажиллагаа

ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БАГЦ: Үр дүн 1: Зорилтот аймгуудын зудад нэрвэгдсэн малчин өрхүүдийн амьжиргаа болох малыг хамгаалах боломжтой болсон.	Зудын хамааралтай малын хорогдлыг хамгийн багадаа 20 хувиар бууруулснаар энэхүү зорилтод хүрнэ.															
Үр дүн 1: Зудын нөлөөллийг зөв цагт хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний үр дүнд иргэдийн амьжиргааг тогтвортой хадгалсан.	7 аймгийн 45,750 малчин өрхөд малын тэжээл олгож, тэдний амьжиргаа доошлох эрсдэлийг бууруулсан.															
Төлөвлөсөн үйл ажиллагаа	Хугацаа (долоо хоног)															
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
Хэрэгцээ шаардлага, чадавхи болон завсардлыг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээ																
Үр ашгийг хүртэгсдийг тодорхойлох, баталгаажуулах																
Малын нэмэгдэл тэжээлийн бэлэн байдлыг тодорхойлох орон нутгийн зах зээлийн дүн шинжилгээ																
Улс, аймаг, сумын түвшин дэх нөөцийн дүн шинжилгээ																
Малын нэмэгдэл тэжээлийн худалдан авалт																
Нөлөөлөлд өртсөн газар нутаг/хүн амд тараах																
Тусламжийн ашиглалтыг хянах																
Тусламжийг үнэлэх																
Үр дүн 2: Чадавхийг бэхжүүлэх ба байгууллагын хөгжлийн зорилтыг чиглүүлнэ	Дэмжлэгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хууль эрхзүй, санхүүгийн бүтэц, механизм бий бөгөөд чадавхитай															
Төлөвлөсөн үйл ажиллагаа	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
Харилцан зөвлөлдсөний үндсэн дээр хэрэгжилтийн бүтцийг тодорхойлох																
Шуурхай хариу арга хэмжээ авах ажилтанг ажиллуулах																
Явцын хяналт: Онцгой байдлын үйл ажиллагааны төвөөр (ОБЕГ) дамжуулан мэдээлэл солилцох																

Үр дүн 3: Үр дүнтэй, хүчирхэг мэдээллийн хэрэгслээр дамжуулан үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад илүү алсыг харсан, хариуцлагатай, ил тод байдлыг хангана	ХХАХҮЯам болон Дэлхийн Банк нь төслийн мэдээлэл түгээх үйл ажиллагааг үр дүнтэй явуулна															
Төлөвлөсөн үйл ажиллагаа	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
Засгийн газрын хүсэлтийн дагуу зохион байгуулж буй үйл ажиллагааны нээлт																
Хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүрэлдэхүүнийг тодорхойлох																
Хэвлэлийн төлөөлөгчийг сонгох																
Хэвлэл мэдээллийн байгууллагатайгаа холбогдсон, мэдээллийг түгээх																
Зорилтот бүлгийнхэнтэй холбогдох, оролцогч талуудын хооронд итгэлцэл бий болгох зорилгоор газар дээр нь очиж уулзах																
Хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг хянах, олон нийтийн ойлголтыг үнэлэх																
ТУСЛАМЖИЙН БАГЦ: Үр дүн 2: КОВИД 19, зуд, цасан болон шороон шуурганы нэгдсэн нөлөөлөлд өртсөн малчин өрхүүд нь амьжиргаагаа залгах боломжтой болсон.	Бэлэн мөнгөний дутагдалд орж, анхан шатны хэрэгцээгээ хангаж чадахгүйгээс амьжиргаа доошилсныг багасгаснаар энэхүү зорилтод хүрнэ															
Үр дүн 1: Малчин өрхүүдийн КОВИД 19, зуд, цасан болон шороон шуурганы нэгдсэн нөлөөллийг бууруулах нэг удаагийн бэлэн мөнгөний тусламж нь тэдэнд тулгамдаж буй онцгой байдлын үед үүссэн хэрэгцээ шаардлага болон бүүрсан орлогын зөрүүг арилгах үр дүнтэй дэмжлэг болно.	Бүх 21 аймаг болон Улаанбаатар хотын 180,000 гаруй малчин өрхөд 100,000 төгрөгийн тусламжийг орлогын хомстлоос үүссэн анхан шатны хэрэгцээгээ хангахад нь дэмжих.															
Төлөвлөсөн үйл ажиллагаанууд	Хугацаа (долоо хоног)															
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
Хэрэгцээ шаардлагын шуурхай үнэлгээ																
Ашиг хүртэгчдийг тодорхойлох, баталгаажуулах																
Бэлэн мөнгөний шилжүүлэгт бүх малчин өрх хамрагдсаныг баталгаажуулах Төрийн сан болон бусад системийн шинжилгээ																

Сонгогдсон малчин өрхүүдэд бэлэн мөнгө шилжүүлэх																	
Бэлэн мөнгөний шилжүүлэгт бүх малчин өрх хамрагдсаныг баталгаажуулах хяналт болон ГШМ хэрэгжүүлэх																	
Тусламжийг үнэлэх																	
Үр дүн 2: Чадавхыг бэхжүүлэх, байгууллагын хөгжлийн зорилтуудад дэмжлэг үзүүлсэн	Даван туулах чадавхыг бэхжүүлэх ажиллагаануудыг төлөвлөж, гүйцэтгэхэд хууль эрх зүй, ёс зүй болон санхүүгийн суурь, систем болон бүтэц, чадамж болон чадавх шаардлагатай																
Төлөвлөсөн үйл ажиллагаанууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1 3	1 4	1 5	1 6	
Зөвлөлдсөний дагуу хэрэгжилтийн бүтцийг гаргасан																	
Шуурхай тусламжийн систем тохируулагдсан																	
Явцын хяналт: Төрийн сан болон бусад зохистой системүүдээр мэдээлэл болон гомдлыг дамжуулах																	
Үр дүн 3: Явцын турш үр дүнтэй, нягт харилцаа холбоогоор дамжуулан илүү хариуцлагатай, ил тод байна.	ХХААХҮЯ, Сангийн яам, болон Дэлхийн Банк нь тусламжийн үйл ажиллагаануудыг үр дүнтэй харилцаа, холбоогоор олон нийтэд мэдээлнэ.																
Төлөвлөсөн үйл ажиллагаанууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1 3	1 4	1 5	1 6	
Засгийн газрын тогтоолын дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлсэн																	
Хэвлэл мэдээллийн төрлүүдийг сонгосон / тодорхойлсон																	
Төлөөлөгчийг сонгосон																	
Хэвлэл мэдээллийг оролцуулж, мэдээлэл тараасан																	
Хэвлэл мэдээллийн хяналт болон олон нийтийн ойлголтын үнэлгээ																	
<u>ДАВАН ТУУЛАХ, ДАСАН</u> <u>ЗОХИЦОХ БАГЦ:</u> Үр дүн 3: Улсын болон бүс нутгийн уур амьсгалын даван туулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлэх, гадаад орчны шок болон сөрөг нөлөөллийг тэсвэрлэх	Байгалийн гамшигт үзэгдлүүдэд хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, зүд болон өвлийн бусад онцгой байдлын үеийн малын огцом хорогдлыг хязгаарлах зэрэг чадавхыг бэхжүүлэх замаар энэхүү зорилтод хүрнэ.																
Үр дүн 1: Малчин иргэдийг зүд болон өвлийн бусад онцгой байдлын үеийн нөлөөллийг тэсвэрлэх, тэжээлийн үйлдвэрлэлийн зах зээлд хялбар хүрэх болон ойрхон байрладаг тэжээл нийлүүлэгчидтэй холбогдох илүү үр дүнтэй системээр хангах.	Бүс нутгийн стратегийн байршлуудад 2-3 малын тэжээлийн үйлдвэрлэлийн нэгжүүдийг Бүтээмжит түншлэлийн хүрээнд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн аргачлалаар өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын дагуу зардал хуваах зарчмаар дэмжих мөн үйл ажиллагааг нь эхлүүлэх, иргэдэд суурилсан чадавхыг бэхжүүлэх үзүүлэх сургалтыг зохион байгуулах																

Төлөвлөсөн үйл ажиллагаанууд	Хугацаа (долоо хоног)															
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
Бүс нутгийн малын тэжээлийн үйлдвэрийн цэгүүдийн стратегийн боломжит байршлуудыг тогтоох, үнэлэх																
БТЗ-д нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах																
Саналын урилгыг боловсруулж, зарлах																
Санал ирүүлэх урилгыг зарлах, танилцуулах арга хэмжээ зохион байгуулах																
Хураангуй санал хүлээн авч, үнэлгээг хийх																
Хураангуй саналын богино жагсаалтыг үүсгэж дэлгэрэнгүй бизнес санал ирүүлэх хүсэлт хүргүүлэх																
Дэлгэрэнгүй бизнес санал хүлээж авах																
Дэлгэрэнгүй бизнес саналын үнэлгээг хийж, сонгогдсон ашиг хүртэгч нартай холбогдох гэрээг байгуулах																
Тэжээлийн үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэх																
Хөрөнгө оруулалтын үнэлгээг хийх																
Үр дүн 2: Чадавхыг бэхжүүлэх болон байгууллагын хөгжлийн зорилтуудад дэмжлэг үзүүлсэн.	Даван туулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлэх ажиллагаануудыг төлөвлөж, гүйцэтгэхэд хууль эрх зүй, ёс зүй болон санхүүгийн суурь, систем болон бүтэц, чадамж болон чадавх шаардлагатай															
Төлөвлөсөн үйл ажиллагаанууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
Зөвлөлдсөний дагуу хэрэгжилтийн бүтцийг гаргасан																
Зорилтот газруудад иргэдэд тулгуурласан үзүүлэх сургалтын багцыг хөгжүүлж, хэрэгжүүлсэн.																
Явцын хяналт: Үзүүлэх сургалтын багцын үнэлгээнд дэмжлэг үзүүлсэн																
Үр дүн 3: Явцын турш үр дүнтэй, нягт харилцаа холбоогоор дамжуулан илүү хариуцлагатай, ил тод байна.	ХХААХҮЯ, Сангийн яам, болон Дэлхийн Банк нь тусламжийн үйл ажиллагаануудыг үр дүнтэй харилцаа, холбоогоор олон нийтэд мэдээлнэ.															
Төлөвлөсөн үйл ажиллагаанууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
Засгийн газрын тогтоолын дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлсэн																
Хэвлэл мэдээллийн төрлүүдийг сонгосон / тодорхойлсон																

Төлөөлөгчийг сонгосон														
Хэвлэл мэдээллийг оролцуулж, мэдээлэл тараасан														
Хэвлэл мэдээллийн хяналт болон олон нийтийн ойлголтын үнэлгээ														

МАНЭЭЭЭНТ-ийн ОНБҮХХАХБХ-ийн гарын авлагад онцгой нөхцөл байдалд хариу үзүүлэх бүрэлдэхүүний санхүүжилтийн байгаль орчин, нийгмийн хамгааллын менежментийн бодлогод МАНЭЭЭЭНТ-ийн одоо байгаа БОНХМБ-г ашиглана гэж тусгасан байна. Энэхүү бичиг баримт нь МАНЭЭЭЭНТ (Р 165945)-ийн Бүрэлдэхүүн 4. Онцгой нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний бүрэлдэхүүн хэсгийн БОНХМБ-ын нэмэлт баримт бичиг болно. МАНЭЭЭЭНТ-ийн БОНХМБ болон энэхүү нэмэлт баримт бичиг нь байгалийн гамшиг болох, зуд тохиолдох өндөр эрсдэлтэй үед гүйцэтгэх хариу арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг дэх байгаль орчин, нийгмийн хамгааллын эрсдлийн менежментийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх зорилготой. Тодруулбал энэхүү нэмэлт баримт бичиг нь дараах зорилготой:

- Санал болгож байгаа ОНБҮХХАХБХ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тохиолдож болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл ба үр нөлөөг үнэлэх, тухайн эрсдэл/үр нөлөөг бууруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг санал болгох
- Санал болгосон БОН-ийн арга хэмжээний хэрэгжилтийг хариуцах байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох

2. Байгаль орчин, нийгмийн эрсдлийн ерөнхий үнэлгээ

ОНБҮХХАХБХ-ийн хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагаа бүрт байгаль орчин, нийгмийн хамгааллын ерөнхий үнэлгээ хийсэн байхыг шаардана. Зудын гамшигт өртсөн аймаг суманд амьдарч байгаа малчин өрхөд эхний ээлжинд малын болон нэмэгдэл тэжээлийг ханган нийлүүлэх, хүргүүлэх нь ОНБҮХХАХБХ-ийн санал болгож буй үндсэн үйл ажиллагаа юм. Хүснэгт 2-т ОНБҮХХАХБХ-ийн ажлын хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгож буй үйл ажиллагааны БОН-ийн тохиолдож болзошгүй нөлөөллийг тодорхойлсон. Ихэнх ажил болон үйл ажиллагаа нь тухайлбал хэвлэл мэдээллийн байгууллагатайгаа холбоо тогтоох, мэдээллийг ил тод болгох зэрэг нь тохиолдож болзошгүй сөрөг нөлөө бага эсвэл маш бага учраас цаашид урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагагүй болно.

Хүснэгт 2 ОНБҮХХАХБХ-ийн үйл ажиллагааны БОН-ийн ерөнхий үнэлгээ

Но.	ОНБҮХХАХБХ-ийн үйл ажиллагаа	Тохиолдож болзошгүй БОН-ийн эрсдэл ба нөлөөлөл	БОН-ийн эрсдэл ба нөлөөллийн түвшин
Үр дүн 1: Зудын нөлөөллийг бууруулах арга хэмжээг цаг алдалгүй нь хэрэгжүүлсэнээр иргэдийн амьжиргааны аюулгүй байдлыг сайжруулна.			
1	Хэрэгцээ шаардлага, чадавхи болон завсардлыг тодорхойлох шуурхай үнэлгээ	Үнэлгээний ажлын шинж чанараас хамааран эрсдэл байхгүй	Тодорхойлогдохгүй
2	Үр ашгийг хүртэгсдийг тодорхойлох, баталгаажуулах	Ажлын шинж чанараас хамааран эрсдэл байхгүй	Тодорхойлогдохгүй
3	Малын өвс, нэмэгдэл тэжээлийн бэлэн байдлыг тодорхойлох орон нутгийн зах зээлийн дүн шинжилгээ	Дүн шинжилгээний шинж чанараас хамааран эрсдэл байхгүй	Тодорхойлогдохгүй
4	Улс, аймаг, сумын түвшин дэх нөөцийн дүн шинжилгээ	Дүн шинжилгээний шинж чанараас хамааран эрсдэл байхгүй	Тодорхойлогдохгүй
5	Малын нэмэгдэл тэжээлийн худалдан авалт	Утас болон имэйл зэрэг арга хэрэгслээр дамжуулан ханган	Бага

		<p>нийлүүлэгчийг сонгох нь байгаль орчин эсвэл орон нутгийн иргэдэд аливаа нөлөө үзүүлэхгүй боловч төрөөс баримтлах хууль тогтоомж, журамд заасан тохирох шаардлагыг хангаагүй ханган нийлүүлэгчдийг сонгосны улмаас тухайлбал тэжээл үйлдвэрлэгчид байгаль орчны менежментийн төлөвлөгөө байхгүй, ахуйн хог хаягдлыг буруу зайлуулсаны улмаас хог хаягдал, дуу чимээний бохирдол зэрэг байгаль орчинд шууд бус сөрөг нөлөөлүүд тохиолдож болзошгүй.</p> <p>Ханган нийлүүлэгч болон тэдгээрийн гэрээт гүйцэтгэгч нар нь Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал (ХЭМАБ)-ын арга хэмжээг хангалтгүй хэрэгжүүлсэний улмаас ХЭМАБ-тай холбоотой асуудлууд үүсч болзошгүй.</p>	
6	Нөлөөлөлд өртсөн газар нутаг/хүн амд тараах	<p>Малын нэмэгдэл тэжээлийг тээвэрлэх явцад автозам дээр унагах, алдагдах</p> <p>Тээвэрлэлтийн явцад үүсэх дуу чимээ</p> <p>Тээврийн хэрэгслээс ялгарах утаа</p> <p>Тээврийн хэрэгсэл байхгүй, цаг агаар муу болон замын байдал муу байгаагийн улмаас эмзэг бүлгийн малчид нэмэгдэл тэжээл авахаар сумын төвд очих боломжгүй байх</p> <p>Цаг агаар, замын нөхцөл байдал муу, жолооч замын хөдөлгөөний дүрмийг мөрдөөгүйн улмаас үүссэн осол, гэмтэл</p> <p>Нийгмийн эерэг нөлөө: малын өвс, нэмэгдэл тэжээлийн үр шимийг орон нутгийн хүн ам болон малчин өрх хүртэнэ.</p>	Бага
7	Тусламжийн ашиглалтыг хянах	Байхгүй	Тодорхойлогдохгүй
8	Тусламжийг үнэлэх	Байхгүй	Тодорхойлогдохгүй
Үр дүн 2: Чадавхийг бэхжүүлэх байгууллагын хөгжлийн зорилтыг чиглүүлнэ.			
9	Харилцан зөвлөлдсөний үндсэн дээр хэрэгжилтийн бүтцийг тодорхойлох	Ажлын шинж чанараас хамааран эрсдэл байхгүй	Тодорхойлогдохгүй
10	Шуурхай хариу арга хэмжээг авах ажилтанг ажиллуулах	Ажлын шинж чанараас хамааран эрсдэл байхгүй	Тодорхойлогдохгүй

11	Явцын хяналт: Онцгой байдлын үйл ажиллагааны төвөөр (ОБЕГ) дамжуулан мэдээлэл солилцох	Байхгүй	Тодорхойлогдохгүй
Үр дүн 3: Үр дүнтэй, хүчирхэг мэдээллийн хэрэгслээр дамжуулан үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад илүү алсыг харсан, хариуцлагатай, ил тод байдлыг хангана.			
12	Засгийн газрын хүсэлтийн дагуу зохион байгуулж буй үйл ажиллагааны нээлт	Байхгүй	Тодорхойлогдохгүй
13	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүрэлдэхүүнийг тодорхойлсон байх	Байхгүй	Тодорхойлогдохгүй
14	Хэвлэлийн төлөөлөгчийг сонгосон байх	Байхгүй	Тодорхойлогдохгүй
15	Хэвлэл мэдээллийн байгууллагатайгаа холбоо тогтоох, мэдээллийг түгээсэн байх	Байхгүй	Тодорхойлогдохгүй
16	Зорилтот бүлгийнхэнтэй холбогдох, оролцогч талуудын хооронд итгэлцэл бий болгох зорилгоор газар дээр нь очиж уулзах	Томилолтоор явах үед тээврийн хэрэгслээс ялгарах утаа Цаг агаар, замын нөхцөл байдал муу, жолооч замын хөдөлгөөний дүрмийг мөрдөөгүйн улмаас үүссэн осол, гэмтэл Эрүүл мэндийн ажилтны зөвлөсөн эрүүл мэндийн зөвлөмжийг дагаж мөрдөөгүйн улмаас оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоох явцад КОВИД 19-ын халдварт өртөх болон/эсвэл халдвар тараах	Бага
17	Хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг хянах, олон нийтийн ойлголтыг үнэлэх	Байхгүй	Тодорхойлогдохгүй
ТУСЛАМЖИЙН БАГЦ:			
Үр дүн 2: КОВИД 19, зуд, цасан болон шороон шуурганы нэгдсэн нөлөөлөлд өртсөн малчин өрхүүд нь амьжиргаагаа залгах боломжтой болсон.			
Үр дүн 1: Малчин өрхүүдийн КОВИД 19, зуд, цасан болон шороон шуурганы нэгдсэн нөлөөллийг бууруулах нэг удаагийн бэлэн мөнгөний тусламж нь тэдэнд тулгамдаж буй онцгой байдлын үед үүссэн хэрэгцээ шаардлага болон бүүрсан орлогын зөрүүг арилгах үр дүнтэй дэмжлэг болно.			
18	Хэрэгцээ шаардлагын шуурхай үнэлгээ	Байхгүй	Тодорхойлогдохгүй
19	Ашиг хүртэгчдийг тодорхойлох, баталгаажуулах	Нас барсан малчдад олгох, системд бүртгэлд ороогүй малчдад олгохгүй байх эрсдэл үүсэх магадлалтай	Бага
20	Бэлэн мөнгөний шилжүүлэгт бүх малчин өрх хамрагдсаныг баталгаажуулах Төрийн сан болон бусад системийн шинжилгээ	Байхгүй	Тодорхойлогдохгүй
21	Сонгогдсон малчин өрхүүдэд бэлэн мөнгө шилжүүлэх	Байхгүй	Тодорхойлогдохгүй
22	Бэлэн мөнгөний шилжүүлэгт бүх малчин өрх хамрагдсаныг баталгаажуулах хяналт болон ГШМ хэрэгжүүлэх	Байхгүй	Тодорхойлогдохгүй

23	Тусламжийг үнэлэх	Байхгүй	Тодорхойлогдохгүй
Үр дүн 2: Чадаврыг бэхжүүлэх, байгууллагын хөгжлийн зорилтуудад дэмжлэг үзүүлсэн			
24	Зөвлөлдсөний дагуу хэрэгжилтийн бүтцийг гаргасан	Байхгүй	Тодорхойлогдохгүй
25	Шуурхай тусламжийн систем тохируулагдсан	Байхгүй	Тодорхойлогдохгүй
26	Явцын хяналт: Төрийн сан болон бусад зохистой системүүдээр мэдээлэл болон гомдлыг дамжуулах	Байхгүй	Тодорхойлогдохгүй
Үр дүн 3: Явцын турш үр дүнтэй, нягт харилцаа холбоогоор дамжуулан илүү хариуцлагатай, ил тод байна.			
27	Засгийн газрын тогтоолын дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлсэн	Байхгүй	Тодорхойлогдохгүй
28	Хэвлэл мэдээллийн төрлүүдийг сонгосон / тодорхойлсон	Байхгүй	Тодорхойлогдохгүй
29	Төлөөлөгчийг сонгосон	Байхгүй	Тодорхойлогдохгүй
30	Хэвлэл мэдээллийг оролцуулж, мэдээлэл тараасан	Байхгүй	Тодорхойлогдохгүй
31	Хэвлэл мэдээллийн хяналт болон олон нийтийн ойлголтын үнэлгээ	Байхгүй	Тодорхойлогдохгүй
ДАВАН ТУУЛАХ, ДАСАН ЗОХИЦОХ БАГЦ:			
Үр дүн 3: Улсын болон бүс нутгийн уур амьсгалын даван туулах, дасан зохицох чадаврыг бэхжүүлэх, гадаад орчны шок болон сөрөг нөлөөллийг тэсвэрлэх			
Үр дүн 1: Малчин иргэдийг зуд болон өвлийн бусад онцгой байдлын үеийн нөлөөллийг тэсвэрлэх, тэжээлийн үйлдвэрлэлийн зах зээлд хялбар хүрэх болон ойрхон байрладаг тэжээл нийлүүлэгчидтэй холбогдох илүү үр дүнтэй системээр хангах.			
32	Бүс нутгийн малын тэжээлийн үйлдвэрийн цэгүүдийн стратегийн боломжит байршлуудыг тогтоох, үнэлэх	Хийсэн үнэлгээнд тулгуурлан тэжээлийн үйлдвэр шинээр барих, сэргээн засварлах төслүүдийг санхүүжүүлсэн тохиолдолд байгаль орчин, нийгмийн нөлөөлөл үүсч болзошгүй.	Дунд
33	БТЗ-д нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах	Байхгүй	Тодорхойлогдохгүй
34	Саналын урилгыг боловсруулж, зарлах	Байхгүй	Тодорхойлогдохгүй
35	Санал ирүүлэх урилгыг зарлах, танилцуулах арга хэмжээ зохион байгуулах	Байхгүй	Тодорхойлогдохгүй
36	Хураангуй санал хүлээн авч, үнэлгээг хийх	Байхгүй	Тодорхойлогдохгүй
37	Хураангуй саналын богино жагсаалтыг үүсгэж дэлгэрэнгүй бизнес санал ирүүлэх хүсэлт хүргүүлэх	Төслийн саналын шатанд төслийн санхүүжүүлэх боломжгүй үйл ажиллагааг сонгох	Бага
38	Дэлгэрэнгүй бизнес санал хүлээж авах	Байхгүй	Тодорхойлогдохгүй
39	Дэлгэрэнгүй бизнес саналын үнэлгээг хийж, сонгогдсон ашиг хүртэгч нартай холбогдох гэрээг байгуулах	Байхгүй	Тодорхойлогдохгүй
40	Тэжээлийн үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэх	Мэдээлэл, материалууд хангалтгүйн улмаас үндэсний цөөнхийг орхигдуулах	Бага
41	Хөрөнгө оруулалтын үнэлгээг хийх	Байхгүй	Тодорхойлогдохгүй

Үр дүн 2: Чадавхыг бэхжүүлэх болон байгууллагын хөгжлийн зорилтуудад дэмжлэг үзүүлсэн.			
42	Зөвлөлдсөний дагуу хэрэгжилтийн бүтцийг гаргасан	Байхгүй	Тодорхойлогдохгүй
43	Зорилтот газруудад иргэдэд тулгуурласан үзүүлэх сургалтын багцыг хөгжүүлж, хэрэгжүүлсэн.	Байхгүй	Тодорхойлогдохгүй
44	Явцын хяналт: Үзүүлэх сургалтын багцын үнэлгээнд дэмжлэг үзүүлсэн	Байхгүй	Тодорхойлогдохгүй
Үр дүн 3: Явцын турш үр дүнтэй, нягт харилцаа холбоогоор дамжуулан илүү хариуцлагатай, ил тод байна.			
45	Засгийн газрын тогтоолын дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлсэн	Байхгүй	Тодорхойлогдохгүй
46	Хэвлэл мэдээллийн төрлүүдийг сонгосон / тодорхойлсон	Байхгүй	Тодорхойлогдохгүй
47	Төлөөлөгчийг сонгосон	Байхгүй	Тодорхойлогдохгүй
48	Хэвлэл мэдээллийг оролцуулж, мэдээлэл тараасан	Байхгүй	Тодорхойлогдохгүй
49	Хэвлэл мэдээллийн хяналт болон олон нийтийн ойлголтын үнэлгээ	Байхгүй	Тодорхойлогдохгүй

3. Болзошгүй нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Байгаль орчин, нийгмийн эрсдлийг хамгийн бага хэмжээнд байлгах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагагүй. Гэсэн хэдий ч Онцгой нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг (ОНБУХХАХБХ) дэх Байгаль орчин ба Нийгмийн нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахын тулд дараах арга хэмжээг авна.

Хүснэгт 3 Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Но.	Байгаль орчин ба нийгмийн болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
1	Малын тэжээлийн үйлдвэрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө байхгүй, ахуйн хог хаягдлыг буруу зайлуулсаны улмаас хог хаягдал, дуу чимээний бохирдол зэрэг байгаль орчинд шүүд бус сөрөг нөлөөлүүд үүсгэж болзошгүй, төрөөс баримтлах хууль тогтоомж, журамд заасан тохирох шаардлагыг хангаагүй ханган нийлүүлэгчдийг сонгох Ханган нийлүүлэгч болон тэдгээрийн гэрээт гүйцэтгэгч нар нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд (ХЭМАБ)-ийн арга хэмжээг хангалтгүй хэрэгжүүлсэний улмаас ХЭМАБ-тай холбоотой үүссэн асуудлууд	МАНЭЗЭНТ-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-ийн Худалдан авалтын журмын дагуу төрөөс баримтлах хууль тогтоомж, журамд заасан тохирох шаардлагыг хангасан дор дурдсан зөвшөөрөл бүхий ханган нийлүүлэгчийг сонгоно: <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээ - Байгаль орчин, аялал жуулчлалын яам, эсвэл аймаг, хотын Байгаль орчин, аялал жуулчлалын газраар батлуулсан байгаль орчинд нөлөөлөл байдлын үнэлгээ (БОНБУ) -ний тайлан - Байгаль орчин, аялал жуулчлалын яам эсвэл аймаг, хотын Байгаль орчин, аялал жуулчлалын газраар жил бүр батлуулдаг байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) - Малын нэмэгдэл тэжээлийн чанарыг баталгаажуулсан баримт бичиг нь Монгол Улсын Стандарт MNS 1077:

		<p>2008 Малын нэмэгдэл тэжээл Техникийн шаардлагад нийцсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> - Газар ашиглах эрхийн гэрчилгээ, гэрээ - Орон нутгийн удирдах байгууллагатай хийсэн хог хаягдал зайлуулах тухай гэрээ - Шаардлагатай тохиолдолд ус ашиглах гэрээ <p>МАНЭЭЭЭНТ-ийн ТХН-ийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь малын өвс, нэмэгдэл тэжээл ханган нийлүүлэгчид болон тэдгээрийн гэрээт гүйцэтгэгч нарыг ажлаа эхлэхээс өмнө тэдэнд зориулж Дэлхийн Банкны хамгааллын бодлого, байгаль орчин, нийгмийн асуудлын зохицуулах төрөөс баримтлах хууль тогтоомж, журмыг танилцуулах онлайн сургалтыг (Монгол Улсад Ковид-19-ийн халдвар тархахаас сэргийлж хөл хорио тогтоосны улмаас) зохион байгуулна.</p> <p>МАНЭЭЭЭНТ-ийн ТХН-ийн Худалтан авалтын мэргэжилтэн нь Дэлхийн банкны хамгааллын бодлого, төрөөс баримтлах зохицуулалтын шаардлагыг малын нэмэгдэл тэжээл ханган нийлүүлэгчид, түүнчлэн бусад гэрээт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг, гэрээнд тусгана.</p>
2	<p>Малын нэмэгдэл тэжээлийг тээвэрлэх явцад автозам дээр унагаах, алдагдах</p> <p>Тээвэрлэлтийн явцад үүсэх дуу чимээ</p> <p>Малын нэмэгдэл тэжээлийг тээвэрлэх болон зорилтот аймаг, сумдад томилолтоор явах үед тээврийн хэрэгслээс ялгарах утаа</p> <p>Тээврийн хэрэгсэл байхгүй, цаг агаар муу болон замын байдал муу байгаагийн улмаас эмзэг бүлгийн малчид малын нэмэгдэл тэжээл авахаар сумын төвд очих боломжгүй байх</p> <p>Цаг агаар, замын нөхцөл байдал муу, жолооч замын хөдөлгөөний дүрмийг мөрдөөгүйн улмаас үүссэн осол, гэмтэл</p>	<p>Малын нэмэгдэл тэжээл ханган нийлүүлэгчид нь БОМТ, тээвэрлэлтийн үеийн эрүүл ахуй, аюулгүй байдал, хүрээлэн буй орчны (ЭААББО) журмуудыг мөрдөж, Төрөөс баримтлах хууль дүрэм, журам, Дэлхийн банкны хамгааллын бодлого, Дэлхийн банкны Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын Ерөнхий удирдамж (2007)-тай нийцэж байгаа эсэхийг МАНЭЭЭЭНТ-ийн ТХН-ийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн хянана.</p> <p>МАНЭЭЭЭНТ-ийн ТХН-ийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь Малыг нэмэгдэл тэжээл ханган нийлүүлэгчдийн ажилтнуудыг ЭМАБХО -ны чиглэлээр ажлын байранд нь зохион байгуулсан сургалтанд бүрэн хамруулсан, сурсан дадлаа тогтмол хэрэгжүүлж байгаа зэргийг хянана.</p>

	<p>МАНЭЭЭЭНТ-ийн ТХН-ийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь тухайн байгууллагын удирдлагуудаас ЭМАБХО-ны сургалтын холбогдох тоон мэдээллийг авна.</p> <p>МАНЭЭЭЭНТ-ийн ТХН-ийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн Гэрээт гүйцэтгэгч малын нэмэгдэл тэжээлийг суурьшлийн бүсээр дамжин өнгөрч тээвэрлэх явцад болзошгүй дуу чимээ үүсгэхээс зайлсхийх эсвэл түүнийг хамгийн бага түвшинд байлгаж байгаа эсэхийг хянана.</p> <p>МАНЭЭЭЭНТ-ийн ТХН-ийн Худалдан авалтын мэргэжилтэн нь Гэрээт гүйцэтгэгч хорт утааны ялгарлыг багасгах, эсвэл түүнийг арилгах зорилгоор тээврийн хэрэгслийн зохих техникийн шаардлагыг баримталж байгаа эсэхийг хянана.</p> <p>МАНЭЭЭЭНТ-ийн ТХН-ийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь малын нэмэгдэл тэжээл ханган нийлүүлэгчид болон тэдгээрийн гэрээт гүйцэтгэгч нарыг ажлаа эхлэхээс өмнө тэдэнд зориулж Дэлхийн Банкны хамгааллын бодлого, байгаль орчин, нийгмийн асуудлын зохицуулах төрөөс баримтлах хууль тогтоомж, журмыг танилцуулах онлайн сургалтыг (Монгол Улсад Ковид-19-ийн халдвар тархахаас сэргийлж хөл хорио тогтоосны улмаас) зохион байгуулна.</p> <p>МАНЭЭЭЭНТ-ийн ТХН нь малын нэмэгдэл тэжээл тараахад ядуу, эмзэг бүлгийн өрхүүдийг хамруулах зорилгоор орон нутгийн хамтрагч байгууллагуудаар (ОБЕГ-ын салбар салбарууд) дамжуулж тээвэрлэлтийг зохион байгуулна.</p> <p>Тээвэрлэгч нь осол гаргах эрсдэлийг бууруулах зорилгоор аюултай зам маршрутаар явах, шөнийн цагаар тээвэрлэлт хийхээс зайлсхийнэ.</p> <p>Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн үргэлжлэх хугацаанд хязгаар тогтоох, жолоочийг уртасгасан цагаар жолоо барьж ядрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор ээлжийн жолоочийг дагалдуулна.</p> <p>Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл эсвэл эд ангиас шалтгаалан үүсч болзошгүй ноцтой</p>
--	--

		аюул ослыг багасгах зорилгоор үйлдвэрлэгчийн зөвшөөрөгдсөн техникийн эд ангийг ашиглан автотээврийн хэрэгслийн байнгын засвар үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.
3	Эрүүл мэндийн ажилтны зөвлөсөн эрүүл мэндийн зөвлөмжийг дагаж мөрдөөгүйн улмаас оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоох явцад КОВИД 19-ын халдварт өртөх болон/эсвэл халдвар тараах	ДЭМБ болон Монгол Улсын Эрүүл Эрүүл мэндийн ажилтны зөвлөсөн КОВИД 19-ын халдвараас урьдчилан сэргийлэх талаархи эрүүл мэндийн зөвлөмжийг бүх ажилтнууд даган мөрдөнө.
4	Нас барсан малчдад олгох, системд бүртгэлд ороогүй малчдад олгохгүй байх эрсдэл үүсэх магадлалтай	<p>ХХАХҮЯам нь аймаг дахь салбаруудаар дамжуулан малчин өрхүүдийн бүртгэлийн мэдээллийг баталгаажуулна.</p> <p>Ингэхдээ малчин өрхүүдийн мэдээллийг статистикийн төв газраас авч, аймгийн салбаруудаар давхар нягтлуулах ба бэлэн мөнгийг малчдын дансанд шилжүүлэхийн өмнө Монгол Банк давхар шалгаж, баталгаажуулна.</p> <p>ХХАХҮЯам нь өөрийн веб сайт, МААЭЗЭН төслийн веб сайт, тэдгээрийн сошиал медиа хуудсуудаар дамжуулан малчдад бэлэн мөнгөний дэмжлэг олгохтой холбоотой мэдээллийг бүх иргэдэд хүргэнэ. Түүнчлэн, төслийн мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх үүднээс төслийн баримт, материалуудыг Халх, Казак хэлээр давхар бэлтгэж, видео материалуудыг хадмал болон дохионы хэлний орчуулгатай гаргана.</p> <p>Алс хязгаарлагдмал газар оршин суух малчин өрхүүд мэдээлэл авах боломжгүй тохиолдолд орон нутгийн засаг захиргааны байгууллага, нэгжүүдээр дамжуулан мэдээллийг хүргэнэ.</p> <p>МААЭЗЭН төслийн нэгж нь төсөлтэй холбоотой гомдол санал хэрхэн гаргах тухай мэдээллийг нийтэд ил байлгаж, төслийн бүх баримт бичигт давхар дурдаж байна. Төсөлтэй холбоотой гомдол саналыг төслийн веб хуудас, цахим хуудсууд болон ХХАХҮЯамны 107 тусгай дугаараар дамжуулан хүлээн авч, шуурхай шийдвэрлэнэ.</p>
5	Хийсэн үнэлгээнд тулгуурлан тэжээлийн үйлдвэр шинээр барих, сэргээн засварлах төслүүдийг санхүүжүүлсэн тохиолдолд байгаль орчин, нийгмийн нөлөөлөл үүсч болзошгүй.	Тэжээлийн үйлдвэр шинээр барих, сэргээн засварлах хүсэлтэй газрууд төслийн санал ирүүлэхдээ байгаль орчин, нийгмийн нөлөөллийг судалж, тэдгээрийг арилгах, бууруулах хариу арга хэмжээг тодорхойлсон байна.

6	Төслийн саналын шатанд төслийн санхүүжүүлэх боломжгүй үйл ажиллагааг сонгох	МАОЭЗЭНТ-ийн ТХН-ийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь малын нэмэгдэл тэжээл ханган нийлүүлэгчид болон тэдгээрийн гэрээт гүйцэтгэгч нарыг ажлаа эхлэхээс өмнө тэдэнд зориулж Дэлхийн Банкны хамгааллын бодлого, байгаль орчин, нийгмийн асуудлын зохицуулах төрөөс баримтлах хууль тогтоомж, журмыг танилцуулах онлайн сургалтыг (Монгол Улсад Ковид-19-ийн халдвар тархахаас сэргийлж хөл хорио тогтоосны улмаас) зохион байгуулна.
7	Мэдээлэл, материалууд хангалтгүйн улмаас үндэсний цөөнхийг орхигдуулах	ТХН нь төслийн мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх үүднээс төслийн баримт, материалуудыг Халх, Казак хэлээр давхар бэлтгэж, видео материалуудыг хадмал болон дохионы хэлний орчуулгатай гаргана. Түүнчлэн цаатан хүмүүст гар утас, радио суваг ашиглан мэдээллийг хүргэнэ.

ОНБҮХХАХБХ-д албадан нүүлгэн шилжүүлэлт ба/эсвэл нөөцийн болон амьжиргааны хүртээмжийг хязгаарлахад хүргэх газар чөлөөлөлтийн асуудлыг тусгаагүй болохыг Хүснэгт 1-д харуулсан. Түүнчлэн, ОНБҮХХАХБХ-ийн үйл ажиллагаагаар МАОЭЗЭНТ-ийн БОНХМБ-д тусгаагүй аливаа стандарт, шаардлагыг дэмжихгүй учраас төслийн одоо байгаа хамгааллын хэрэглэгдэхүүнийг өөрчлөхгүй. Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012) –д заасны дагуу ОБҮХАХБХ-ийн үйл ажиллагаанд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх шаардлагагүй.

4. Байгаль орчин ба нийгмийн менежментийн үйл ажиллагаа

ОНБҮХХАХБХ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ МАОЭЗЭНТ-ийн БОНХМБ-ын 7-р бүлэгт заасан байгаль орчин, нийгмийн менежментийн үйл ажиллагааг баримтална.

5. Байгууллагын зохион байгуулалт ба чадавхийг бэхжүүлэх

ХХААХҮЯ нь МАОЭЗЭНТ-ийн ТХН-ээр дамжуулан энэхүү нэмэлт баримт бичигт тусгасан болон ОНБҮХХАХБХ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулах, хянах үүргийг хүлээх бөгөөд аймгууд дахь салбаруудаараа дамжуулан орон нутгийн зохицуулалтын үндсэн үүрэг гүйцэтгэгч ОБЕГ-тай нягт уялдаатай хамтран ажиллана.

БОНХМБ-ын Нэмэлтийг хэрэгжүүлэх МАОЭЗЭНТ-ийн ТХН ба байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь МАОЭЗЭНТ-ийн БОНХМБ-ын нэмэлтэд тусгасан үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хяналт үнэлгээ ба тайлагнах. МАОЭЗЭНТ-ийн БОНХМБ-ын нэмэлтийг хянах, зохицуулах, тайлагнах нь ОНБҮХХАХБХ-ийн хэрэгжилтийн салшгүй хэсэг мөн. Энэхүү БОНХМБ-ын нэмэлт баримт бичигт нарийвчлан тусгасан үйл ажиллагааг МАОЭЗЭНТ-ийн ТХН-ийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцан зохицуулж тайлагнана.

Зөвлөлдөх хэлэлцүүлэг ба мэдээллийг ил тод болгох. МАОЭЗЭНТ-ийн ТХН нь энэхүү баримт бичгийг ХХААХҮЯ-ны вэбсайтад байршуулах замаар мэдээллийг ил тод болгоно. ОНБҮХХАХБХ-

ийн санал болгож буй харилцаа холбоо/мэдээллийн төлөвлөгөөг зудын хариу арга хэмжээний түргэвчилсэн үнэлгээний баримт бичигт тусгасан.

ОНБҮХХАХБХ-ийн хүртээмжтэй байдлыг хангах, оролцогч талуудын зөвлөлдөх хэлэлцүүлгийн үр ашигтай төлөвлөгөөг боловсруулах зорилгоор үндсэн оролцогч талуудыг тодорхойлсон бөгөөд үүнд дор дурдсан хувь хүмүүс, бүлгүүд эсвэл бусад байгууллагууд хамрагдана:

- ОНБҮХХАХБХ-ээр ("нөлөөлөлд өртсөн талууд" гэж нэрлэх) шууд эсвэл шууд бусаар, эерэг эсвэл сөрөг нөлөөлөлд өртөх эсвэл өртөж болзошгүй.
- ОНБҮХХАХБХ-ийн үйл ажиллагаанд хамрагдах боломжтой ('бусад оролцогч талууд' гэж нэрлэх). Үүнд ОНБҮХХАХБХ-ийн үйл ажиллагааны хэрэгжилтэд ялгаатай байдлаар оролцож болох хувь хүмүүс эсвэл бүлгүүд хамрагдана.
- Хөгжлийн бэрхшээлтэй/эмзэг бүлэгт хамрагдах хувь хүн эсвэл бүлгүүд. Энэхүү бүлэгт тусламж, нөөцийн тэгш хуваарилалтад хамрагдах боломж хязгаарлагдмал, алслагдсан нутагт амьдардаг, 200-аас цөөн толгой малтай малчид багтана.

ОНБҮХХАХБХ-ийн нөлөөлөлд өртсөн талууд:

- ОНБҮХХАХБХ-ийн үйл ажиллагаа хэрэгжих аймаг, сумын малчин өрхүүд болон малчид

ОНБҮХХАХБХ-ийн оролцогч талууд:

- ОБЕГ (Коронавируст халдварын тархалтын эсрэг хариу арга хэмжээ авч хөдөлгөөний хязгаарлалт хийсэн учраас малын тэжээл тээвэрлэх том оврын тээврийн хэрэгсэлд холбогдох зөвшөөрөл олгох, өөрийн орон нутгийн салбаруудаар дамжуулан тэжээлийг хүлээн авч аймгийн төвөөс сүм руу тээвэрлэх)
- Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа (отрын бэлчээрийг ашиглаж эсвэл оторлож байгаа малчин өрхүүдэд малын тэжээл хүргэх)
- Зам, Тээврийн Хөгжлийн Яам (малын тэжээлийг аймгаас сүмдэд хүргэж тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд хөдөөгийн замаар нэвтрэх боломжийг бүрдүүлэх)
- Аймгийн Засаг дарга (сүмдэд малын тэжээл хүргэх, шаардлагатай бүх ажлыг аймгийн төвд зохион байгуулж гүйцэтгэх)
- Сумын Засаг дарга (бүх малчин өрхүүд өөрсдөд нь зориулагдсан малын тэжээлийг цаг алдалгүй хүлээж авсан эсэхийг хянах)
- Орон нутгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар (нийгмийн түргэвчилсэн үнэлгээнд туслах)
- Аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар (тэжээл түгээх ажилд дэмжлэг үзүүлэх, малчин өрхүүдийн мэдээлэл гаргах)
- Сангийн Яам (малчин өрхүүдэд бэлэн мөнгөний дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах)
- ТХН (санхүү, худалдан авалт, хяналт шинжилгээ, байгаль орчин, нийгмийн асуудлуудыг хариуцан ажиллах)

Хөгжлийн бэрхшээлтэй/эмзэг бүлгийн иргэд ба бүлэг:

- 200 болон түүнээс цөөн тооны малтай ядуу өрхүүд
- Өрх толгойлсон малчид
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- Үндэстний цөөнх болон ялгаатай хэл соёлтой цөөнх бүлэг

ОНБҮХХАХБХ-ийг хэрэгжүүлэх явцад оролцогч талуудын зөвлөлдөх хэлэлцүүлэг нь бүтээлч, үр өгөөжтэй харилцааг хөгжүүлдэг. Энэ нь ХХААХҮЯ-нд ОНБҮХХАХБХ-ийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар оролцогч талуудын тулгамдсан асуудлыг ойлгох боломжийг бүрдүүлэх бөгөөд үүнийг нь төслийн ашиг шим, үр нөлөөг дээшлүүлэхэд ашиглана. Түүнчлэн энэ нь эрт шатанд байгаль

орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлсоноор урьдчилан сэргийлэх, нэн даруй арилгах боломжийг олгодог. ОНБҮХХАХБХ-ийг хэрэгжүүлэхдээ цахим уулзалт, чухал мэдээлэл солилцох ярилцлага болон оролцогч талуудын зөвлөлдөх санал асуулга зэрэг хэлбэрийг ашиглана. ОНБҮХХАХБХ-ийн зөвлөлдөх хэлэлцүүлгийн төлөвлөгөөг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 4 ОНБҮХХАХБХ-ийн зөвлөлдөх хэлэлцүүлэг

Но.	Оролцогч талууд	Хэлэлцүүлгийн сэдэв	Хэрэглэх аргачлал	Байршил /Давтамж	Хариуцах эзэн
1	ОНБҮХХАХБХ-ийн үр шимийг хүртэгчид эсвэл малчин өрхүүд	ОНБҮХХАХБХ-ийн танилцуулга, төлөвлөсөн үйл ажиллагааны мэдээлэл, холбогдох эрсдэл ба бууруулах арга хэмжээ ОНБҮХХАХБХ-ийн үр дүн	Цахимаар ярилцах	Цахимаар/ ОНБҮХХАХБХ-ийн хэрэгжилтийн эхэн ба төгсгөл үед	ТХН
2	Орон нутгийн засаг захиргаа	ОНБҮХХАХБХ-ийн танилцуулга, төлөвлөсөн үйл ажиллагааны мэдээлэл, холбогдох эрсдэл ба бууруулах арга хэмжээ ОНБҮХХАХБХ-ийн үр дүн	Цахимаар ярилцах	Цахимаар/ ОНБҮХХАХБХ-ийн хэрэгжилтийн эхэн ба төгсгөл үед	ТХН
3	Төрийн байгууллагууд эсвэл оролцогч талууд	ОНБҮХХАХБХ-ийн явцийн шинэчлэсэн мэдээлэл ОНБҮХХАХБХ-ийн үр дүн ба гол ололт амжилт	Цахимаар ярилцах	Цахимаар/Тогтмол	ТХН

ОНБҮХХАХБХ-ийн үйл ажиллагааг төлөвлөх шатанд ХХААХҮЯ нь хөтөлбөрт хамрагдах болон бусад аймаг, сумдын малчин өрх, орон нутгийн удирдлагатай зөвлөлдөх уулзалт хийж, төлөвлөж буй хөтөлбөр, тэдгээрийн болзошгүй нөлөөлөл, холбогдох хариу арга хэмжээг танилцуулж, санал авсан. Зөвлөлдөх уулзалтын хураангуйг хүснэгт 5-д харуулав.

Хүснэгт 5 Зөвлөлдөх уулзалтын хураангуй

№	Огноо, байршил	Оролцогч	Зорилго	Санал
1	2021 оны 1 сарын 4	Б.Адъяатогтох	Төлөвлөж буй үйл ажиллагаа, түүнтэй холбоотой үүсч болзошгүй байгаль	Малчид отор нүүдэл их хийж байгаа. Сумын 700 гаруй малчин өрхийн 310 орчим нь 10 аймгийн 44 суманд отор

	Утсаар ярьсан	Өвөрхангай аймгийн Сант сумын Засаг дарга	орчин, нийгмийн эрсдэл, авах хариу арга хэмжээг танилцуулж, санал авах	нүүдэл хийж байна. Малчдад тэжээл, бусад тусламж нэн шаардлагатай байна.
2	2021 оны 1 сарын 4 Утсаар ярьсан	Д.Бямбатогтох Өвөрхангай аймгийн Баянгол сумын Засаг дарга	Төлөвлөж буй үйл ажиллагаа, түүнтэй холбоотой үүсч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, авах хариу арга хэмжээг танилцуулж, санал авах	Дийлэнхи малчид отроор явж байна. Зарим малчид өөр аймгуудад, зарим нь өөрийн аймгийн бусад сумдад ото хийж байна. Цаг агаарын байдал хэцүү болж байгаа тул Дундговь аймаг руу отроор явсан зарим малчид эргэн ирж байна. Малчид утасны сүлжээнд сайн холбогдсон тул мэдээлэл түгээж, тэжээл хүргэхэд аливаа хүндрэл үүсэхгүй байх.
3	2021 оны 1 сарын 4 Утсаар ярьсан	Ц.Лхамсүрэн Өвөрхангай аймгийн Сант сумын малчин	Төлөвлөж буй үйл ажиллагаа, түүнтэй холбоотой үүсч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, авах хариу арга хэмжээг танилцуулж, санал авах	Манайх Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд отроор явж байна. Манай сумаас 150 орчим км зайд байдаг газар. Мал бэлчих аргагүй цас ихтэй байна. Үхэр гэрийн гаднаас гарахгүй тэжээл өгөөд л байж байна. Бид намар мал зарж олсон ихэнхи орлогоо тэжээл худалдаж авахад зарцуулж байна. Хөдөө орон нутагт тэжээл нилээд үнэтэй байна. Тэжээлийн тусламж ирнэ гэдэгт их баяртай байна. Тэжээл суманд ирлээ гэвэл ямар нэг аргаар очиж авна. Хүний нутагт түлш байхгүй, нүүрс худалдаж авч түлж байна.
4	2021 оны 1 сарын 4 Утсаар ярьсан	Баасанмаа Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг дарга	Төлөвлөж буй үйл ажиллагаа, түүнтэй холбоотой үүсч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, авах хариу арга хэмжээг танилцуулж, санал авах	Тэжээлийн тусламж малчдад нэн хэрэгцээтэй байгаа. Энэ зун манай нутагт их гантай байсан. Манай сумын малчин өрхүүдийн 43 хувь нь Говь-Алтай аймгийн Дарви, Хөхморьт зэрэг сумд руу оторт явсан. Малын тоо нилээн буурч байгаа. Өмнө нь 300-с доош малтай айл 10 орчим байдаг байсан бол энэ жил 300 орчим өрх бүртгэгдсэн. Малчид тэжээл их сураглаж байгаа. Малчид утасны сүлжээнд сайн

				холбогдсон тул мэдээлэл түгээж, тэжээл хүргэхэд аливаа хүндрэл үүсэхгүй байх.
5	2021 оны 1 сарын 4 Утсаар ярьсан	Цэвэгдорж Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг дарга	Төлөвлөж буй үйл ажиллагаа, түүнтэй холбоотой үүсч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, авах хариу арга хэмжээг танилцуулж, санал авах	Манай сумын малчид отроор Архангай, Булган, зарим нь бүр Төв аймаг хүртэл явсан. Малчид тэжээл их сураглаж байгаа. Сумын төвтэй ойрхон, 40-50 км зайд байдаг айлууд тэжээлээ хүрч ирж авахад аливаа хүндрэл үүсэхгүй байх. Харин хол зайтай айлуудад хүргэхэд бага сага асуудал үүсч магадгүй.
6	2021 оны 1 сарын 4 Утсаар ярьсан	Г.Даваадалай Өвөрхангай аймгийн Сант сумын малчин	Төлөвлөж буй үйл ажиллагаа, түүнтэй холбоотой үүсч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, авах хариу арга хэмжээг танилцуулж, санал авах	Сумын төвөөс хойш байдаг. Цас их орсон. Унаа явахад хэцүү байх, халтиргаа гулгаа их байгаа. Над шиг сумандаа байгаа айлууд гайгүй, сум ороод тэжээлээ авч болно. Отроор явж байгаа айлуудын хувьд харин хүндрэл үүсч магадгүй, тэжээл очиж авахад. Одоо мал идэх юм ер нь алга.
7	2021 оны 1 сарын 4 Утсаар ярьсан	Н.Гантулга Өвөрхангай аймгийн Сант сумын малчин	Төлөвлөж буй үйл ажиллагаа, түүнтэй холбоотой үүсч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, авах хариу арга хэмжээг танилцуулж, санал авах	Өвөлжилт хүнд байгаа. Улам хүндэрч магадгүй. Тэжээлийн тусламж малчдад маш их хэрэгцээ шаардлагатай. Бид нар байгаа бүх мөнгөө тэжээл авахад зарцуулж байна. Малаа зарж банкны зээлээ төлнө гэсэн төлөвлөгөө бүтэхгүй болоод хэцүүхэн л байна.
8	2021 оны 1 сарын 4 Утсаар ярьсан	Д.Галбаатар Архангай аймгийн Цахир сумын Засаг дарга	Төлөвлөж буй үйл ажиллагаа, түүнтэй холбоотой үүсч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, авах хариу арга хэмжээг танилцуулж, санал авах	Зудын эрсдлийн үнэлгээ 9, 10 сард хийгдэхэд нөхцөл байдал Архангай аймагт ийм хүнд байгаагүй. Архангай аймгийн хойд 3 сумын хувьд нөхцөл байдал маш хүнд, өвөлжилт хүндэрч байна. Олон айл өрхүүд отроор явсан. Дэмжлэг байдаг бол одоо л хэрэгтэй байна. Малчид жижиг малаа алдаад эхэлсэн. Зам халтиргаа гулгаа ихтэй, гадаа маш их хүйтэрч байгаа тул тэжээл тээврийн жолооч нар машины болон хувийн бэлтгэл маш сайн хангаж, бэлтгэлийг шат шатандаа шалгаж, аюулгүй байдлыг хангах хэрэгтэй. Үгүй

				бол ямар нэг эвдрэл гэмтэл гарвал жолооч нар зам дээр осгох ч эрсдэлтэй.
9	2021 оны 3 сарын 17 Дэлхийн Банкны цахим уулзалт	Монголмаа Дэлхийн Банкны Нийгмийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Төслийн хүрээнд малчин өрхүүдэд бэлэн мөнгөний дэмжлэг олгох саналын тухай танилцуулах	Энэхүү дэмжлэг маш чухал ба боломжтой тохиолдолд нэн ядуу, эмзэг өрхүүдэд нэмэлт дэмжлэг олгоход анхаарах
10	2021 оны 3 сарын 17 Дэлхийн Банкны цахим уулзалт	Жигжидмаа НҮБХХАБ	Төслийн хүрээнд малчин өрхүүдэд бэлэн мөнгөний дэмжлэг олгох саналын тухай танилцуулах	Энэхүү дэмжлэг маш чухал, цаг үеэ олсон байна. Ялангуяа Дундговь аймгийн хувьд нөхцөл байдал тун хүнд байна.
11	2021 оны 3 сарын 17 Дэлхийн Банкны цахим уулзалт	А.Эрдэнэ Дэлхийн Банкны санхүүгийн мэргэжилтэн	Төслийн хүрээнд малчин өрхүүдэд бэлэн мөнгөний дэмжлэг олгох саналын тухай танилцуулах	Энэхүү дэмжлэгийг олгохын өмнө малчин өрхүүдийн бүртгэл, дансны дугааруудыг шалгах, баталгаажуулах шаардлагатай.

Хөгжлийн бэрхшээлтэй / эмзэг бүлгийн иргэдийн үзэл бодлыг тусгах стратеги

ОНБҮХХАХБХ-ийн зудын гамшигт өртөж болзошгүй эмзэг бүлгийн малчин өрхүүдийг дэмжих, тэдэнд туслах зэрэг тэргүүлэх чиглэлийн хүрээнд ХХААХҮЯ нь эдгээр хүмүүсийн ОНБҮХХАХБХ-ийн оролцогч талуудын уулзалтанд оролцох, ОНБҮХХАХБХ-тэй холбоотой мэдээ мэдээллийг хүлээн авахад учирч болзошгүй саад, бэрхшээлийг тодорхойлсон. ОНБҮХХАХБХ-ийн мэдээллийг ил тод болгох, оролцогч талуудын зөвлөлдөх тогтолцоог эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгардаг бэрхшээл, сул талуудтай үялдуулан зохицуулдаг бөгөөд МААЭЗЭНТ-ийн ТХН нь эдгээр оролцогчдын хэрэгцээнд тохирох тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Зарим эмзэг бүлгийн өрхүүд уулзалтанд оролцох боломжгүй тохиолдолд ТХН нь шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглан уулзалтыг зохион байгуулна.

Сургалт ба чадавхийг бэхжүүлэх. МААЭЗЭНТ-ийн ТХН нь бүх ажилтнуудад ОНБҮХХАХБХ-н төлөвлөсөн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаар тодорхой ойлголтыг өгөх ёстой. Иймд МААЭЗЭНТ-ийн ТХН-ийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь малын нэмэгдэл тэжээл ханган нийлүүлэгчид болон бусад хамтрагч оролцогчдыг ажлаа эхлэхээс нь өмнө тэдэнд зориулж Дэлхийн Банкны хамгааллын бодлого, Төрөөс баримтлах хууль тогтоомж, журмыг танилцуулах онлайн сургалтыг (Монгол Улсад Ковид-19-ийн халдвар тархахаас сэргийлж хөл хорио тогтоосны улмаас) зохион байгуулна.

6. Гомдол шийдвэрлэх механизм

ОНБҮХХАХБХ-д МAAЭЗЭНТ-ийн БОНХМБ-д заасан гомдол хянан шийдвэрлэх механизмыг (ГХШМ) ашиглана. Хувь хүн, иргэд энэхүү ОНБҮХХАХБХ-ийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртсөн гэж үзсэн тохиолдолд өөрсдийн гомдлоо МAAЭЗЭНТ-ийн вэбсайт болон ХХАХҮЯамны тусгай дугаар 107-р дамжуулан ирүүлэх боломжтой. Төслийн 4-р бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтэд оролцож буй төрийн байгууллагуудтай холбоотой гомдол, саналыг Засгийн Газрын тусгай дугаар 11-11-т ирүүлэх боломжтой.